



"Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-ын Хавсралт №1

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой. Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаагаа явуулж буй үнэт цаас гаргагчид хамаарна. Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар "тайлбар" хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	2026.04.30
Үнэт цаас гаргагчийн нэр:	"Мандал Даатгал" ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	MNDL
Салбарын ангилал:	Даатгалын үйл ажиллагаа
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	
Тайлангийн хамрах хугацаа:	2025.01.01-2025.12.31
Хариуцсан албан тушаалтны овог, нэр, албан тушаал, холбоо барих и-мэйл хаяг, утас:	Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал Б.Бат-Эрдэнэ (И-мэйл хаяг: Bat-erdene.b@mandal.mn, Утас: 88929299)
Тайланг баталгаажуулсан Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан)	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

	Бүлэг	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
		Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд							
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх		Тийм		Компанийн дотоод системд нийт ажилтнууд харах боломжтойгоор байршуулсан байдаг.	Компанийн Гүйцэтгэх захирлын 2025.09.29-ний өдрийн №25/121 тоот тушаалаар "Тогтвортой хөгжлийн бодлого"-ыг шинэчлэн баталсан. Тус бодлогод тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг тусгасан байдаг.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх		Тийм				RI103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компанид тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх		Тийм			Ажлын албатай.	RI103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		Тийм		Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал,	Гүйцэтгэх удирдлагын түвшинд хэрэгжүүлдэг.	GRI 102
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		Тийм		Ерөнхий нягтлан бодогч, Комплаенс нийцлийн менежер, Хүний нөөцийн ахлах менежер, Маркетингийн ахлах менежер, Оффис менежер	Хавсран гүйцэтгэх байдлаар хэрэгжүүлдэг. Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирлаар ахлуулсан ажлын албатай.	GRI 102
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		Тийм				GRI 102
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?		Тийм			Гүйцэтгэх удирдлагын түвшинд хэрэгжүүлэн ажилладаг.	GRI 102
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх		Тийм			Одоогоор байхгүй байна.	SASB
MS4.1		Чадавч бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр		Тийм	цаг		Компанийн 2026 оны сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	GRI 102
MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?		Тийм			Гүйцэтгэх удирдлагын түвшинд хэрэгжүүлдэг.	GRI 102, SDG 12

MS4.3		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?		Тийм			Тогтвортой хөгжлийн тайланг жилийн үйл ажиллагааны тайлангаас тусад нь гаргаж, жилд 1 удаа тайлагнадаг.	GRI 102, SDG 12
MS5.1			Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?		Тийм			Олон улсын стандартын дагуу тайлагнадаг.	GRI 102, SDG 12
MS5.2		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?		Үгүй			Хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр судалж байна.	GRI 102, SDG 17
Байгаль, орчны шалгуур үзүүлэлтүүд									
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	93,125	103,453	Mera Втц '000	Түлшний эрчим хүч	Компанийн үйл ажиллагаанд 2 цахилгаан хөдөлгүүртэй авто машин ашигладаг тул цахилгааны зарцуулалт нэмэгдсэн үзүүлэлттэй гарч байна.	GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	0.05%	103,453	Mera Втц '000		Оффисын хэмжээнд өндөр ватт бүхий гэрлүүдийг бага ватт бүхий гэрлээр сольж бүрэн шинэчилж цахилгааны хэмнэлтийг би болгосон.	GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)		Үгүй	TU & % Гкал		Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Зарцуулалт - 9600л, Хэмнэлт - 3180л	Зарцуулалт - 8033л, Хэмнэлт - 1567л	Литр/кг & %, ГЖоуль, Tergel		Компанийн үйл ажиллагаанд ашигладаг нийт авто машины 25%-ийг цахилгаан хөдөлгүүртэй авто машин болгож түлш зарцуулалтыг бууруулсан.	GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь		Үгүй	%		Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна	SFRD
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь		Үгүй	%		Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна	GRI 302, SDG 7
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	29.856тн	24.984тн	CO2/тонн		1тн түлш шатаахад 3.11 тн CO ₂ ялгаруулна.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	9.88тн	4.8тн	CO2/тонн		1тн түлш шатаахад 3.11 тн CO ₂ ялгаруулна.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	8.25тн	9тн	CO2/тонн	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлын эсрэг ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж Өрөл, Голтбор, Далан хайс, Шар хуайс, Хайлаас, Улиас, Бургас зэрэг 11 төрлийн 550 мод тарьсан.	550 мод жилд ойролцоогоор 8.25 тонн хүлэмжийн хий (CO ₂) шингээдэг.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой уу?		Тийм		Компанийн дотоод системд нийт ажилтнууд харах боломжтойгоор байршуулсан байдаг.	Компанийн Гүйцэтгэх захирлын 2025.05.29-ний өдрийн №25/076 тоот тушаалаар "Ногоон хөгжлийн бодлого"-ыг шинэчлэн баталсан.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)		Тийм			Манай компани нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл болон боломжийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл ажиллагааг компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үе шаттайгаар нэвтрүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд бид олон улсын сайн туршлага, зөвлөмжийг баримтлан ажиллаж байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт нь зуд, ган, үер, шороон шуурга зэрэг байгалийн гамшгийн давтамж, эрчим нэмэгдэх хэлбэрээр илэрч байгаа нь даатгалын салбарт шууд нөлөөлж байна. Үүнтэй уялдуулан манай компани Стресс тест, Эрсдэлийн удирдлага ба боломж, Зохицуулалт ба тайлагнал чиглэлээр үнэлгээ хийж байна. Цаашид бид уур амьсгалын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгох, өгөгдөл болон загварчлалыг сайжруулах, мөн дотоод чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана. Ингэснээр компанийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдал, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	312,495,801	151,226,548	Tergel		2025 онд байгалийн эрсдэлийн улмаас учирсан 65 даатгалын тохиолдолд 151,226,548 төгрөгийн нөхөн төлбөрийг олгож шийдвэрлэсэн.	GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	17,609,000	17,609,000	Tergel		Компанийн хэмжээнд 4 ширхэг ногоон хүлэмжийн төхөөрөмжийг байршуулсан байдаг.	GRI 201, TCFD, SDG 13

E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм	Тийм	Тийм		Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд цаасны хэрэглээг бууруулах, Цахилгаан эрчим хүчээ хэмнэх, Хог хаягдлыг ангилан ялгах, Усны зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, Ногоон худалдан авалтыг хийхийн зэрэгцээ Ногоон хөгжлийг дэмждэг, хэрэгжүүлдэг шинэ харилцагч байгууллагад үнийн хөнгөлөлт олгон хамтран ажилладаг.	GRI, SASB, World Economic Forum
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	520	576	м3/л	-		GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	130	-	м3/л	Ус алдалтын эсрэг усны мэдрэгч болон даралт бууруулагч байрлуулж, усны хэрэглээг бууруулах арга хэмжээ авсан.	GRI 303, SDG 6	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь		-	%	Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	GRI 303, SDG 6	
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ		-	м3/л	Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	GRI 303, SDG 6	
E5.1		Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ			тонн	Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	GRI 306, SDG 12	
E5.2	Хатуу хог хаягдал	Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	15		%	Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг ангилдаг бөгөөд цаас болон хуванцар хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг байгууллагад нийлүүлдэг.	GRI 306, SDG 12	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)		-	тонн	Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна	GRI 306, SDG 12	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	0,04	0,04	%	"Мандал Санхүүгийн Нэгдэл"-ийн хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Тэнгэр төгөл"-ийг байгуулсан.	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн нь нийт 930 га талбайг хамрах ба бид 430м2 талбайд мод суулгасан.	GRI 304, SDG 15
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо		-	Төрөл зүйлийн тоо		Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээслэсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь		-	%		Эдгээр үзүүлэлтийг одоогоор гаргах боломжгүй байна.	SFRD, IFC Performance Standard 6
Нийгмийн шалгуур үзүүлэлт									
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	32	Тийм	%	2025 онд компанийн хүний нөөцийн тогтвортой байдал 32% байна.	"Мандал Даатгал" ХК нь нийт 127 ажилтантай. Үүнээс 2025 оны 12 сарын байдлаар үндсэн ажилтан 119, туршилтын хугацаанд ажиллаж буй 8 ажилтан байна.	GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	6	Тийм	Тоо		Компанийн бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбоотой 2025 онд нийт 6 ажлын байр шинээр бий болгосон байна. Үүнд: Шинээр байгуулагдсан хэлтсийн ажлын байрууд орно.	GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	48	Тийм	цаг		2025 оны 02 сард "Мандал Академи" онлайн сургалтын платформын үйл ажиллагааг эхлүүлж, нийт ажилтнуудад онлайн болон танхимын нийт 17,500 хүн цагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт 880 хүн цагийн сургалтыг танхимаар олгосон байна. Үүнээс гадны байгууллагаас авсан ур чадвар дээшлүүлэх 8 сургалт, дотооддоо зохион байгуулсан 18 сургалт байна. Нэг ажилтанд ногдох сургалтын цаг 48 цаг.	GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Тийм		Компанийн дотоод системд нийт ажилтнууд харах боломжтойгоор байршуулсан байдаг.	Компанийн Гүйцэтгэх захирлын 2025.05.30-ны өдрийн №25/079 тоот тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам"-ыг шинэчлэн баталсан.	GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь			0%		Одоогоор бүртгэгдсэн осол, гэмтэл байхгүй байна.	GRI 403, SDG 3
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг			1 цаг		Нийслэлийн онцгой байдлын газартай хамтарсан галын сургалт хийгдсэн.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр			Нийт ажилтнууд		Нийт ажилтнуудыг байгууллагаас эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Тус даатгалд урьдчилан сэргийлэх үзлэг, бүх төрлийн амбулаторийн эмчилгээ, үйлчилгээ багтсан байдаг.	GRI 403, SDG 3
S3.1		Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Үгүй			Одоогоор тус журам байхгүй байна.	GRI 405, SDG 5

S3.2	Эрх тэгш байдал	Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Тийм		https://www.mandal.mn/rules	Компанийн Ёс зүйн стандарт болон Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох зохицуулалтуудыг тусгасан.	GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Тийм		https://www.mandal.mn/rules	Компанийн Ёс зүйн стандарт болон Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох зохицуулалтуудыг тусгасан.	GRI 103, SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эм 59.8%, Эр 40.2%	Тийм	%		Нийт ажилтны тоо 127. Үүнээс 76 буюу 59.8% нь эмэгтэй, 51 буюу 40.2% нь эрэгтэй ажилтнууд байна.	GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эм 11%, Эр 89%	Тийм	%		Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэй. 1 буюу 11% нь эмэгтэй, 8 буюу 88% нь эрэгтэй гишүүд байна.	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эм 23.1%, Эр 76.9%	Тийм	%		Удирдлагын түвшний нийт 13 ажилтан байна. Үүний 23.1% нь эмэгтэй, 76.9% нь эрэгтэй ажилтнууд байна.	GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эм 73.9, Эр 26.1%	Тийм	%		Дунд болон анхан шатны нэгжийн нийт 23 ажилтан байна. Үүний 26.1% нь эрэгтэй, 73.9% нь эмэгтэй ажилтнууд байна.	GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	1	Тийм	харьцаа		Компанийн эрэгтэй болон эмэгтэй ажилтнуудын үндсэн цалингийн харьцаа 1 буюу ижил байна.	GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Үгүй			Одоогоор тус журам байхгүй байна.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	1		%		Хөгжлийн бэрхшээлтэй үндсэн ажилтны тоо 2 буюу нийт ажилтны 1%-ийг эзэлж байна.	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу		Тийм			Тус компанийн оффис, ажлын орчин нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдэгдсэн, жишээ нь налуу орц гарц, лифттэй.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо		0	Төгрөг		Байхгүй.	SDG 10
S5.1		Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?		Тийм		https://www.mandal.mn/rules	Компанийн ТУЗ-ийн 2025 оны 12 сарын 09-ний өдрийн №25/018 тоот тогтоолоор "Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого"-ыг батлуулсан. Тус бодлогод оролцогч талуудтай харилцах зарчим, хамтран ажиллах нөхцөлийг тусгасан байдаг.	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)		Үгүй			Одоогоор тус журам байхгүй байна.	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?		Тийм		https://www.mandal.mn/	Компанийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг 7575-2000 лавлах утас, харилцагчийн үйлчилгээний төв болон info@mandal.mn и-мэйл хаягаар тус тус хүлээн авч Гүйцэтгэх захирлын 2025.09.25-ны өдрийн №25/133 тоот тушаалаар батлагдсан "Харилцагчийн гомдол хүлээн авч шийдвэрлэх журам"-ын дагуу шийдвэрлэдэг.	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?		Тийм			Санал хүсэлт, гомдлыг хүлээн авч холбогдох журмын дагуу шийдвэрлэж харилцагчдаа тогтмол мэдээллэн үйлчилгээ үзүүлдэг. Олон нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзвэл "Мэдээлэл харилцааны журам"-ын дагуу мэдээллийг хүргэдэг.	IFC Performance Standards
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%	Тийм	%		Олон нийтээс ирсэн санал, гомдлыг "Харилцагчийн гомдол хүлээн авч шийдвэрлэх журам"-ын дагуу шийдвэрлэдэг ба 2025 оны байдлаар 112 санал гомдол ирсэнийг ажлын 3 өдөрт багтаан 100% шийдвэрлэж, харилцагчид тухай бүр хариу арга хэмжээний талаар мэдэгдсэн.	GRI 413, SDG 8

S5.6	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.001	0,1	%	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг компанийн жилийн тайланд тусгасан байдаг.	Нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. 1. "50 хүний амьсгалах" төслийн хүрээнд дараах 2 ажлыг 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Эхний ажил нь Улсын Гуравдугаар төв эмнэлэгтэй хамтран тархины цус харвалтын дараа бүлэн хайлуулах Алтплаза тарилгын 50 тунг нийлүүлж одоогоор 34 хүний алтан амийг авраад байна. Дараагийн ажил нь Туул голын эрэг дагуух хамгийн их хүн цуглардаг 5 цэг дээр үер усны аюул мэдээлэх цамхагуудыг камерын хамт байршуулсан. Тухайн цамхагаас гол дагуух иргэдэд анхааруулж, сэрэмжлүүлэх мэдээллийг дуут дохио ашиглан хүргэн ажиллах нөхцөлийг бүрдүүлээ. Ингэснээр тухайн цэгүүд дээр хүн эндсэн тохиолдолд бүртгэгдээгүй байна. 2. 4-12 насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгоход чиглэсэн онлайн хичээлүүдийг бэлтгэн нийтэлж, өдгөө 35,000 хүүхэд багачуудад үнэ төлбөргүй олгоод байна. 3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор eDoctor эрүүл мэндийн нэгдсэн платформыг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүгээр дамжуулан бид 1.5 сая гаруй иргэдэд үнэ төлбөргүй эрүүл мэндийн боловсролыг олгож байна. 4. Мандал Санхүүгийн Нэгдлийн охин компаниуд нь Санхүү Эдийн Засгийн Их сургуультай хамтран Санхүү&Банкны бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Үг хөтөлбөрийн хүрээнд нийт 14 оюутныг ажлын байраар хангахын зэрэгцээ, их сургуулийн сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн. Ингэснээр 3 жилийн хугацаанд бакалаврын зэрэг эзэмших бөгөөд онолын ба практик мэдлэгийг эзэмшиж, топ мэргэжилтэн болж төлөвших боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 5. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орчныг сайжруулах зорилгоор Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Мэдрэл судлалын тасгийн Мэдрэлийн болон мэдрэлийн үйл оношийн кабинетын засвар, тохижилтыг санхүүжүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж, төлөвлөгөөт хугацаанд хүлээлгэн өгсөн. Нийгмийн хариуцлагын арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө оруулалт нь нийт орлогын 0.001%-ийг эзэлж байна.	GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		Тийм		Компанийн дотоод системд нийт ажилтнууд харах боломжтойгоор байршуулсан байдаг.	Компанийн Гүйцэтгэх захирлын 2025.06.23-ны өдрийн №25/093 тоот тушаалаар "Худалдан авалтын үйл ажиллагааны журам"-ыг эргэн хяналт хийж, шинэчлэн баталсан.	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	98.12%	98.04%	%		2025 онд 407 ханган нийлүүлэгчээс худалдан авалт хийсний 98.04% нь дотоодын ханган нийлүүлэгч байна.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	16.16%	14.49%	%		2025 оны 407 ханган нийлүүлэгчийн 59 нь ToC хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон ISO удирдлагын тогтолцоотой компаниуд байна.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур									
G1.1	Авлигал болон ёс зүй	Авлигын эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?		Тийм		https://www.mandal.mn/rules	"Мандал Санхүүгийн Нэгдэл" ХХК-ийн хамаарал бүхий компаниудын хэмжээнд дагаж мөрдөх "Ёс зүйн стандарт"-ыг баталсан. Тус стандартад авлигатай холбоотой хэсгийг тусгасан байдаг.	GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33%		%	https://www.mandal.mn/investors#boardOfDirectors	Компанийн тухай хуулийн 75.4-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан. ТУЗ нь нийт 9 гишүүнээс бүрдэх бөгөөд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?		Тийм		https://www.mandal.mn/rules	Компанийн ТУЗ-ийн 2025.12.09-ний өдрийн №25/018 тоот тогтоолын хавсралтаар "Хөрөнгө оруулагчтай харилцах журам"-ыг батлуулсан. Тус журмаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, оролцоог хангах зэрэг зохицуулалтуудыг нарийвчлан тусгасан.	GRI 102, OECD Principle of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?		Тийм		https://www.mandal.mn/rules	Засаглалын баримт бичгүүдийг компанийн цахим хуудсанд байршуулсан байдаг.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?		Тийм		https://www.mandal.mn/rules	Компанийн ТУЗ-ийн 2025 оны 12 сарын 09-ний өдрийн №25/018 тоот тогтоолын хавсралтаар "МУТСТ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон хөтөлбөр"-ийг батлуулсан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Харилцагчийг таньж мэдэх, Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хяналт тавих, мэдээлэх болон Эрсдэлийн удирдлагын аргаар комплаенсын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?		Тийм		Компанийн дотоод системд нийт ажилтнууд харах боломжтойгоор байршуулсан байдаг.	МУТСТ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон хөтөлбөртэй. Мөн компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн стандарт, Шүтлэг үлээх бодлого болон Сургалт хөгжлийн журмаар бусад үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү.)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	1,800	Тийм	Тоо		2025 онд бид санхүүгийн мэдлэг олгохоор бизнес эрхлэгчдэд зориулсан, эцэг эхчүүдэд зориулсан, банк бус санхүүгийн байгууллагын удирдлагуудад зориулсан, иргэдэд зориулсан гэх 4 төрлийн арга хэмжээг үнэ төлбөргүй зохион байгуулж, нийт 1,800 гаруй зочдоод санхүү, эрсдэлийн боловсрол олгосон байна.	SDG 1

